

НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК  
ОНӨААТУГАЗРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧИГЛЭЛЭЭР 2019 ОНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН  
АЖЛЫН ТАЙЛАН

2019 оны 12 дугаар сарын 29

Налайх дүүрэг

**Нэг. Үндсэн үйл ажиллагааны чиглэлээр**

Хүний нөөцийн бодлогын баримт бичгийг дараах 9 үндсэн чиглэлийн дагуу боловсруулан баталсан. Үүнд:

- Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах
- Албан хаагчдыг сургалтаар хөгжүүлэх
- Удирдах албан хаагчдын манлайллын чадварыг хөгжүүлэх
- Албан хаагчдыг ажлын байранд сонгон шалгаруулах
- Хүний нөөцийн нэгдсэн мэдээллийн сан бий болгох, ашиглах
- Хүний нөөцийг эрсдлийн удирдлагаар хангах
- Хүний нөөцийг хөгжүүлэх чиглэлээр гадаад, дотоод хамтын ажиллагааг хөгжүүлэх
- Албан хаагчдын зан үйл, хандлагыг төлөвшүүлэх
- Хүний нөөцийн мэдээллийн ил тод байдлыг бүрдүүлэх

Байгууллагын хүний нөөцийн бодлогын баримт бичгийн хүрээнд шаардлагатай хөтөлбөрүүдийг боловсруулсан. Үүнд:

- Ажилчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр
- Хүний нөөцийн эрсдлээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр
- Шинэ ажилтны дасан зохицох хөтөлбөр

Хөтөлбөрүүдийг 2019-2023 он хүртэл хугацаатайгаар боловсруулж, хөтөлбөрийн хүрээнд хийж гүйцэтгэх ажлыг байгууллагын хүний нөөцийн төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журмын дагуу байгууллагын ажилчдын АБТ-ыг шинэчлэн гаргасан.

UBERP албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн удирдлагын системийн Хүний нөөцийн модулийн мэдээллийг тухай бүр нь шинэчлэн ажилласан.

**Хоёр. Хүний нөөцийн сургалт, хөгжлийн чиглэлээр**

Байгууллагын албан хаагчдаас сургалтын хэрэгцээг тодорхойлох судалгаа авч, Хүний нөөцийн сургалт, хөгжлийн төлөвлөгөө гарган ажилласан. Төлөвлөгөөнд тусгагдсан дараах сургалтуудыг байгууллагын дотоод нөөц бололцоонд тулгуурлан явуулсан. Үүнд:

- Байгууллагын дотоод дүрэм, журам
- Төсөл бичих аргачлал
- Англи хэлний дунд шатны сургалт
- Ажлын байрны ёс зүй, төрийн албан хаагчийн баримтлах зарчим
- Байгууллагын соёл, түүнийг хэрэгжүүлэх сургалт
- Манлайлал, ажлын байрны ур чадварыг нэмэгдүүлэх тухай
- Архив, албан хэрэг хөтлөлт
- Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сургалт

- НЗДТГ, Налайх дүүргийн ЗДТГ, бусад төрийн болон төрийн бус байгууллагаас явуулсан цаг үеийн сургалтуудад албан хаагчдыг хамруулж давхардсан тоогоор нийт 67 ажилтан хамрагдсан.

Байгууллага дотор эерэг хандлагыг түгээх, ажлын байрны сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, хамт олны уур амьсгалыг сайжруулах үүднээс дараах үйл ажиллагааг явуулсан. Үүнд:

- **“Эерэг байцгаая” сарын аян**

Аяны хүрээнд ажлын байранд бүдүүлэг үг, үйлдэл гаргахгүй байх, хамт олноо хүндэтгэх, уурлаж бухимдахгүй байх зэрэг шалгуур үзүүлэлтийн дагуу зохион байгуулж, ажилтнуудын эмоцийг өдөр бүр өөр өөр ажилтнаар үнэлүүлж, хамгийн эерэг болон хамгийн бүдүүлэг ажилтныг тодруулсан.

- **“Кофетой өглөө” өглөөний хэлэлцүүлэг**

Тус хэлэлцүүлгээр бүх ажилчид тогтсон хуваарийн дагуу өөрийн сонгосон сэдвийн хүрээнд 30 минутын дотор бусдад хэрэгтэй мэдээ мэдээлэл өгөх, сургалт явуулах, хөгжөөнт тоглоом тоглуулах зэрэг арга хэмжээг зохиосон.

- **Ажилтнуудын ур чадварын үнэлгээ хийх**

Хүний нөөцийн эрсдэлээс сэргийлэх хөтөлбөрийн хүрээнд ажилтнуудын давуу болон сул талыг 7 төрлөөр удирдлагууд болон хамтран ажиллагсдын үнэлгээгээр гаргаж, аль чиглэлээр түлхүү хөгжүүлэх шаардлагатай болохыг тодорхойлох, өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулахад чиглэн ажилласан. Мөн ажилтнуудтай ажлаас гарах үеийн ярилцлагыг явуулж, ажлаас гарч буй шалтгааныг тодруулан, байгууллагын зүгээс дутагдалтай байсан гэж үзвэл цаашид анхаарах асуудлыг тодорхойлон ажиллаж байна.

- **Спортын арга хэмжээ зохион байгуулах**

Ажилчдын бие бялдрыг хөгжүүлэх, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлж 7 хоногийн Баасан гараг бүр спорт зааланд хичээллэх, улиралд 1 удаа ууланд авирах, цайны цагаар ширээний теннис тоглох болон ажлын байрны дасгал зэргийг хийж байна. Мөн байгууллагын аварга шалгаруулах тэмцээнийг шатар, теннис, дартсын төрлөөр зохион байгуулж аваргаа шалгаруулсан.

## **Гурав. Хүний нөөцийн нийгмийн баталгааг хангах чиглэлээр**

Байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй явуулахад шаардагдах тоног төхөөрөмж, ном гарын авлага, бичиг хэргийн хэрэгсэл болон тэмцээн уралдаанд оролцоход шаардлагатай спортын өмсгөлөөр албан хаагчдыг хангасан.

Налайх дүүргийн Эрүүл мэндийн төвтэй хамтран байгууллагын ажилчдыг эрүүл мэндийн ерөнхий үзлэг шинжилгээнд хамруулсан.

Хүүхдийн баярыг тохиолдуулан ажилчдын нийт 25 хүүхдэд бэлэг олгосон.

Ханиад томууны дэгдэлт ихэссэн болон бусад хүчин зүйлсээс шалтгаалан зайлшгүй чөлөө авах шаардлагатай үед албан хаагчдад цалинтай чөлөө олгож байна.

Албан хаагчдад Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу ээлжийн амралтыг хуваарийн дагуу олгосон.

Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд хууль, дүрэмд нийцүүлэн дараах дэмжлэг, туслалцааг олгосон. Үүнд:

- Шинэ орон сууцад орсон – 3 ажилтан
- Шинэ хүүхэд төрсөн – 1 ажилтан
- Ар гэрийн гачигдал гарсан – 2 ажилтан
- Салбарын ой тохиож буй ажилтанг шагнаж урамшуулсан – 3 ажилтан

- Ажлын үр дүнгээс хамааран улирал бүр үр дүнгийн урамшуулал, сар бүр ур чадварын нэмэгдэл олгосон – нийт ажилчид
- Хоол, унааны нэмэгдэл – нийт ажилчид
- Шинэ жилийн баярыг тохиолдуулан Салбарын болон Нийслэлийн шагнал олгосон–8 ажилтан тус тус шагнаж, нэг удаагийн буцалтгүй тусламж болон шагнал урамшуулал олгосон байна.

#### Дөрөв. Хүний нөөцийн ил тод байдлыг хангах чиглэлээр

Байгууллагад шаардлагатай сул ажлын байрны зарыг тухай бүр нь байгууллагын вебсайт, тухайн ажлын байртай холбогдох цахим сайт, фэйж хуудас болон Налайх дүүргийн Хөдөлмөр, халамжийн хэлтэст мэдээллэж, нийтэлсэн. Тухайлбал:

- Цахилгааны инженер
- Дулааны инженер
- Хуулийн мэргэжилтэн
- Гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтний ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт тус тус зарласан.

Байгууллагын ажилчидтай холбоотой тусламж, дэмжлэг олгох тушаалыг байгууллагын вебсайт болон шилэн дансны мэдээлэлд тухай бүр нь оруулж байна.

ХЯНАСАН:  
ДАРГА

2019 оны 11 дугаар сарын 29-ны өдөр

ТАЙЛАН ГАРГАСАН  
ЗАХИРГААНЫ АЖИЛТАН



С.БАТЖАРГАЛ

Д.НОМИН-ЭРДЭНЭ